



ᠪᠠᠭᠠᠨᠠᠭᠤᠷ ᠳᠦᠭᠦᠷᠭᠢᠨ ᠡᠳᠢᠶᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠳᠤᠯᠢᠨ  
ᠲᠠᠨᠢᠯᠴᠤᠭᠤᠯᠭᠠ










# БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2021/12



БАГАНУУР ДҮҮРЭГ  
2022 он

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	3
 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ҮНЭ ХАНШ	14
 АЖ ҮЙЛДВЭР	16
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	17

## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2021 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	182 583	40 317	9 115	37 216	56 398	39 537
Үүнээс:						
Тэмээ	81	32	-	47	2	-
Адуу	15 137	3 940	752	3 245	3 740	3 460
Үхэр	17 327	4 391	1 453	3 695	4 161	3 627
Хонь	90 373	19 482	4 197	18 398	29 686	18 600
Ямаа	59 665	12 462	2 713	11 831	18 809	13 850

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-XII	2018 I-XII	2019 I-XII	2020 I-XII	2021 I-XII
Суурин хүн ам	тоо	28 787	29 512	29 663	29342	
Төрөлт	тоо	609	654	621	596	568
Нас баралт	тоо	149	147	162	152	187
Шилжиж ирсэн	тоо	709	617	432	960	584
Цэвэр өсөлт	хувь	1.60	1.72	1.55	1.51	1.29'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ






## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр 2021 оны 12 сарын эцэст 305 иргэн ажил хайж бүртгүүлсэн байна. Дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд өнгөрсөн оноос 33 (12.1%) хүнээр өссөн байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 19 (9.3%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 231 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 141 (46.2%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Ажил хайгч иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 52 иргэн ажилд орсон бөгөөд хувьцаат компанид 2, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 13, төсөвт байгууллагад 37 иргэн тус тус ажилд орсон байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 26 (8.5%) нь 15-24 насны, 100 (32.8%) нь 25-34 насны залуучууд, 77 (25.2%) нь 35-44 насныхан, 82 (26.9%) нь 45-60 насны, 20 буюу (6.6%) нь 60-аас дээш насны иргэд байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор, 12 сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2020 XII	2021 XII	2020 XII	2021 XII
Ажилгүйчүүд, бүгд	272	305	151	180
Үүнээс:				
Дээд боловсролтой	62	73	40	54
Тусгай дунд боловсролтой	18	28	12	20
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	26	31	10	17
Ерөнхий боловсролтой	152	162	87	87
Бага болон боловсролгүй	14	11	2	2

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 73 (23.9%) нь дээд боловсролтой, 28 (9.2%) нь тусгай дунд боловсролтой, 31 (10.2%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 162 (53.1%) нь ерөнхий боловсролтой, 11 (3.6%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Ажил хайгч иргэдийн 180 (59.0%) нь эмэгтэйчүүд байна.



#### НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 19.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.6 (3.3%) тэрбум төгрөгөөр, зарлага 30.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.1 (11.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 13.8 (71.0%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 1.3 (5.7%) тэрбум төгрөг тэтгэмжийн сангаас, 1.6 (5.8%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 2.9 (16.4%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 213.6 (1.1%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар



Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2020 I-XII	2021 I-XII	Өсөлт бууралт	
			тоо	хувь
	сая төгрөг			
Сангийн орлого, бүгд	18 766.2	19 386.1	619.9	3.3
тэтгэврийн сан	12 541.8	13 755.8	1 214.0	9.7
тэтгэмжийн сан	1 313.3	1 098.9	-214.4	-16.3
ҮОМШӨ <sup>1</sup> -ний сан	1 598.7	1 129.0	-469.7	-29.4
ЭМД <sup>2</sup> -ын сан	2 983.7	3 188.8	205.1	6.9
ажилгүйдлийн сан	328.7	213.6	-115.1	-35.0
Сангийн зарлага, бүгд	27 076.1	30 199.5	3 123.4	11.5
тэтгэврийн сан	23 718.9	26 609.6	2 890.7	12.2
тэтгэмжийн сан	1 196.1	1 453.5	257.4	21.5
ҮОМШӨ-ний сан	1 771.6	1 774.7	3.1	0.2
ЭМД-ын сан	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	389.5	361.7	-27.8	-7.1

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4671 хүнд 26.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 3562 хүнд 1.5 тэрбум төгрөгийн тэтгэмж, 528 хүнд 1.8 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 212 хүнд 361.7 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 12 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 1.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.2 (56.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь зарим нэр төрлийн халамжийн санхүүжилт нэгдсэн журмаар олгогдсон болсонтой холбоотойгоор буурсан үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 1.6 (95.5%) тэрбум төгрөг улсын төсвөөс, 61.8 (3.6%) сая төгрөг орон нутгийн төсвөөс, 14.9 (0.9%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

### Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2020 I-XII	2021 I-XII	Өсөлт бууралт	
			тоо	хувь
Сангийн орлого	3 968.8	1721.6	-2247.2	-56.6
Улсын төсвөөс	3 886.7	1644.5	-2242.2	-57.7
Орон нутгийн төсвөөс	73.4	61.8	-11.6	-15.8
Бусад орлого	8.7	15.3	6.6	75.9
Сангийн зарлага	3 875.3	1675.5	-2199.8	-56.8
Тэтгэвэр	1 364.0	317.2	-1046.8	-76.7
Тэтгэмж	395.7	340.4	-55.3	-14.0
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	292.9	282.7	-10.2	-3.5
"Алдарт эх" I одонт эхчүүд	120.6	-		
"Алдарт эх" II одонт эхчүүд	134.9	-		
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	8.5	-		
Насны хишиг	236.2	-		
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	31.2	6.3	-24.9	-79.8
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	321.9	193.7	-128.2	-39.8
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	100.1	95.6	-4.5	-4.5
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	695	344.2	-350.8	-50.5
Цалинтай ээж	61.8	-		
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	58.4	-		
ОНО-д түшиглэсэн халамж	42.8	54.1	11.3	26.4
Ихэр хүүхдийн тэтгэмж	4.0	-		
Онцгой тохиолдлын тэтгэмж	-	2.4		
Бусад үйлчилгээ	7.3	38.9	31.6	432.9

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 443 хүнд 317.2 сая төгрөгийн тэтгэвэр, 408 хүнд 340.4 сая төгрөгийн асаргааны тэтгэмж, 1786 ахмад настанд 193.7 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламж үзүүлж, 2974 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 344.2 сая төгрөг, 260 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 282.7 сая төгрөг, 2 хүнд


онцгой тохиодлын тэтгэмж 2.4 сая төгрөг, 299 хүнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж 54.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 474 иргэдэд 95.6 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.



### ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 12 сарын байдлаар 584 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 31 (5.0%) буурсан байна. Энэ хугацаанд 170.9 мянган хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 42.1 (19.8%) мянган хүнээр буурсан бол, хэвтэн эмчлүүлсэн 8.9 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.0 (12.5%) мянган хүнээр өссөн байна.


Зураг 7. Амбулаторийн үзлэг 2021 оны XII сар



Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 12 сард


Үзүүлэлт	2020 I- XII	2021 I-XII	$\frac{2021.I - XI\%}{2020.I - XI}$
Амаржсан эхийн тоо	614	583	-5.0
Үүнээс бусад аймгийн харьяат	160	141	-11.9
Амьд төрсөн хүүхэд	615	584	-5.0
Үүнээс бусад аймгийн харьяат	159	142	-10.7
Эхийн эндэгдэл	1	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	4	4	0.0

Зураг 8. Халдварт өвчин, сараар





Зураг 9. Ковид-19, сараар



2021 оны эхний 12 сарын байдлаар халдварт паразит өвчний 136 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 1.3%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 41 (23.2%) тохиолдлоор буурсан байна. Харин цочмог халдварт өвчний 10027 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 98.7%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 9940 (115.3 дахин) тохиолдлоор өссөн байна.

Тайлант хугацаанд дүүрэгт Ковид-19 өвчний 10005 тохиолдол батлагдсан нь цочмог халдварт өвчний 99.8%-ийг эзэлж байна.

Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 3468.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3444.1 продицимиллээр өссөн байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2020 I-XII	2021 I-XII	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	177	136	-41
Заг хүйтэн	105	65	-40
Тэмбүү	36	37	1
Мөөгөнцөр /кандидоз/	4	1	-3
Трихомониаз	27	29	2
Кандилом	3	2	-1
Хламид	2	2	0
Цочмог халдварт өвчин	87	10 027	9 940
Цусан суулга	21	15	-6
Гепатит А	1	3	2
Салхин цэцэг	33	2	-31
Сальмонеллез	4	2	-2
Гар хөл амны өвчин	5	-	-5
Хачигт рикеттиоз	1	-	-1
Скарлатин	3	-	-3
Ковид-19	-	10 005	10 005
Сүрьеэ	16	21	5
Хоолны хордлого	3	-	-3
Нийт халдварт өвчин	264	10 184	9 920



## ГЭМТ ХЭРЭГ

2021 онд дүүргийн хэмжээнд 163 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20 (14.0%) хэргээр нэмэгдсэн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 56.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.

### Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-XII	2021 I-XII	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	143	163	20	14.0	100.0
Хүний амь нас хохироох	2	-	-2	-100.0	-
Хүний амь нас хохирсон	2	-	-2	-100.0	-
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	72	86	14	19.4	52.8
Бусдын эд хөрөнгө хулгайлах	23	17	-6	-26.1	10.4
Бэлгийн халдашгүй байдал	2	5	3	150.0	3.1
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	1	1	-	0.6
Дээрэмдэх	1	1	0	0.0	0.6
Залилан мэхлэх	15	23	8	53.3	14.1
Худал мэдээлэл тархаах	-	1	1	-	0.6
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	10	9	-1	-10.0	5.5
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	2	1	-1	-50.0	0.6
Мал хулгайлах	5	4	-1	-20.0	2.5
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах	2	-	-2	-100.0	-
Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах	-	2	2	-	1.2
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	4	3	-1	-25.0	1.8
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	2	2	-	1.2
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	-	2	2	-	1.2
Нийтийн ашиг сонирхлын эсрэг	1	-	-1	-100.0	-
Хууль бусаар нийгмийн халамжийн үйлчилгээ авах	-	1	1	-	0.6
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	1	-	-1	-100.0	-
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	-	2	2	-	1.2
Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх	-	1	1	-	0.6
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	2	2	-	1.2
Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах	1	-	-1	-100.0	-
Хэрэг илрүүлэлтийн хувь	58.0	56.9			


Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 86 (52.8%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 23 (14.1%) нь залилан мэхлэх хэрэг, 17 (10.4%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэргүүд байна.

Тайлант хугацаанд хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших хэрэг 9, бэлгийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 5, мал хулгайлах хэрэг 4, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн хэрэг 3, мөрийтэй тоглоом зохион байгуулах хэрэг, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хууль бусаар ашиглах, хууль сахиулагчийг эсэргүүцэх, орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасан, цахим мэдээлэлд хууль бусаар халдсан хэргүүд тус бүр 2, гэр бүлийн хүчирхийлэл, дээрэмдэх, худал мэдээлэл тараах, хууль бусаар нийгмийн халамжийн үйлчилгээ авах, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэсэн хэргүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний XII сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2020 I-XII		2021 I-XII	
	Согтууг аар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	63	30	84	27
Хүний амь нас хохироосон	2	1	-	-
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	60	16	69	15
Бэлгийн халдашгүй байдал	-	-	4	-
Бусдын эд хөрөнгө хулгайлах	-	8	2	4
Залилах	-	-	-	2
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	1	1	-
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	-	3	1	4
Гэр бүлийн хүчирхийлэл	-	-	1	-
Бусдын эд хөрөнгө устгах гэмтээх	-	1	-	-
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	-	-	-	1
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	3	1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	-	-	3	-
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	1	-	-	-
Дүнд эзлэх хувь	44.1	21.0	51.5	16.6

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 84 болж өмнөх оны мөн үеэс 21 (33.3%) хэргээр өссөн бол, гудамж талбайд 27 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (10.0%) хэргээр буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 51.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.4 пунктээр нэмэгдсэн бол гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 15.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна.


Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I-XII сар



Хүснэгт 10. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2020 I-XII	2021 I-XII	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	124	124	-	-
Үүнээс: эмэгтэйчүүд	24	22	-2	-8.3
хүүхэд	8	1	-7	-87.5
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	144	159	15	10.4
Үүнээс: нас барсан	4	-	-4	-100.0
гэмтсэн	79	92	13	16.5
Саатуулагдсан хүний тоо	590	505	-85	-14.4
Баривчлагдсан хүний тоо	180	163	-17	-9.4
Учирсан хохирол /сая төгрөг/	155.5	393.5	238	153.1
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	100.2	57.1	-43.1	-43.0

Зураг 14. Гэмт хэрэгт холбогдсон иргэд, хувиар, 2021 I-XII сар



2021 онд 124 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсны 22 (17.7%) нь эмэгтэйчүүд, 1 (0.8%) нь хүүхэд байна. Тайлант хугацаанд 159 хүн гэмт хэргийн улмаас хохирсон ба үүнээс 92 хүн гэмтснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13 (16.5%) хүнээр нэмэгдсэн байна. Мөн 505 хүн саатуулагдаж, 163 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс саатуулагдсан хүний тоо 85 (14.4%) хүнээр,

баривчлагдсан хүний тоо 17 (9.4%) хүнээр тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 393.5 сая төгрөгийн хохирол учирсны 57.1 (14.5%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.




## ҮНЭ ХАНШ

2021 оны 12 сарын хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2021 оны 12 сарын дундаж үнэ

Бүтээгдэхүүний төрөл			Хэмжих нэгж	Хишиг-Уул Супер маркет	Гэрэл Мини маркет	Номин Супер маркет	Ахиц Хүнсний дэлгүүр	Амтлаг Мини маркет	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг мини маркет
1	Үхэр	ястай	кг					11000	12000	
		цул	кг					12000	12000	
2	Хонь	ястай	кг					9500	9500	
		цул	кг					12000	12000	
3	Ямаа	ястай	кг						9000	
		цул	кг						11000	
4	Адуу	ястай	кг						11000	
		цул	кг						11000	
5	Гурил /Алтан тариа/	Дээд	кг	2200		2199		2500		
		I-р	кг	1450	1500	1339	1450	1500		1600
		II-р	кг	1200	1100		1100	1200		1000
6	Цагаан будaa /1кг/	Алтай сийрис	кг	2800	2750		2800	2800		3000
		слава	кг	2300	4400		2200			2300
7	Сүү /1л/	Өглөө	кг	3250	3400	3259	1650	3100		3400
		Дээж	кг	3250	3300		3250	3200		3200
8	Өндөг	орос	кг	460		499	450			400
		Монгол	кг		500			450		
10	Ургамлы н тос 1л	Олейна	л	7500	7900	7550	7550	7500		8300
		siesta	л	7500	8050		7800	7500		7800
11	Хүнсний ногоо /1кг/ монгол	Төмс	кг	1200	900	1199	1250	1000	1200	1500
		Байцаа	кг	2500	3000	999.5	2000	1500	2000	2000
		Лууван	кг	2300	3600	2999	2500	2500	2500	3200
		Сонгин о	кг	2500	1250	2599	2700	3500	1500	1100
12	Талх /Есөн шанд/	том 900гр	ш	2300	2300	2399	2100	2100		2100
		Дунд 700гр	ш	2100	2200	2269	2000	2000		1000
		Жижиг 500 гр	ш	1750	1750	1799	1600	1600		1500
13	Атар талх		ш	1400	1500		1400	1600		1400
14	Цөцгийн тос	Дээж	кг	2750	5500					5700
		Сүү ХХК	кг				4200			
15	Элсэн чихэр	Цесна	кг	2700	1450		3000	3000		3000

Зураг 15. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 12-р сард



Зураг 16. Нэг кг махны дундаж үнэ, жил бүрийн 12-р сард



Хүснэгт 12. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

	2018 XII	2019 XII	2020 XII	2021 XII
	төгрөг			
Адууны шир	17 000	8 000	7 500	5 000
Үхрийн шир /2.3 метрээс доош/	7 000	5 000	5 000	3 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	13 000	9 000	8 000	7 000
Хонины арьс	2 000	1 500	1 500	2 000

Хүснэгт 13. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2017 XII	2018 XII	2019 XII	2020 XII	2021 XII	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 140	1 480	1 850	1 450	2 200	750	51.7
АИ -92	1 540	1 630	2 000	1 470	2 220	750	51.0
Дизель түлш	1 650	1 720	2 403	2 180	2 900	720	33.0

2021 оны 12 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-92 бензин 750 (51.0%) төгрөгөөр, АИ-80 бензин 750 (51.7%) төгрөгөөр, дизель түлш 720 (33.0%) төгрөгөөр тус тус өссөн байна.




## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2021 оны эцэст 152.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.1 (7.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 14. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2020 I-XII	2021 I-XII	$\frac{2021}{2020}\%$	2020 I-XII	2021 I-XII	$\frac{2021}{2020}\%$
Нүүрс олборлолт	м.тн	4 050.1	4 341.6	107.2	135 678.4	145 445.6	107.2
Дулаан дамжуулалт	м.гкал	164.4	164.1	99.8	5 557.1	5 650.5	101.7
Талх үйлдвэрлэлт	тн	217.4	235.2	108.2	305.4	357.4	117.0
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	45.5	56.1	123.3	414.8	587.4	141.6
Зайлуулсан хог хаягдал	м.м3	51.3	54.3	105.8	496.8	554.3	111.6
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					142 452.5	152 595.2	107.1

Зураг 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар




Тайлант онд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 291.5 (7.2%) мянган тонн, үнийн дүнгээр 9.7 (7.2%) тэрбум төгрөгөөр өссөн бол, дулаан үйлдвэрлэлт биет хэмжээгээр 0.3 (0.2%) мянган гкал-аар буурч, үнийн дүнгээр 93.4 (1.7%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс талхны үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс 17.8 (8.2%) тонноор буюу 52.0 (17.0%) сая төгрөгөөр, нарийн боовны үйлдвэрлэлт 10.6 (23.3%) тонноор буюу 172.6 (41.6%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.


Тайлант хугацаанд 54.3 мянган м3 хог зайлуулсан нь өнгөрсөн оноос 3.0 (5.8%) мянган м3-аар нэмэгджээ.



Зураг 18. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, сая төгрөг



Зураг 19. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн XII сард




### НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 2261.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 279.3 (14.1%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 1314.1 (53.6%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 15. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2020 I-XII	2021 I-XII	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	1 982.4	2 261.7	279.3
Орон сууц	401.7	493.0	91.3
Ус борлуулалт, бүгд	796.4	872.2	75.8
Хүн амд	446.1	477.4	31.3
Аж ахуйн нэгжид	350.3	394.8	44.5
Сувагжуулалт	670.8	733.5	62.7
Бусад	113.5	163.0	49.5

Зураг 20. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 16. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	мянган төгрөг		
Нийт дүн	575 931.7	524 778.4	91.1
Тавлаг өргөө	99 006.0	86 527.8	87.4
Маргад өргөө	105 526.2	84 178.1	79.8
Сод хөгжил	128 698.8	130 914.2	101.7
Шинэ элч	103 148.0	99 661.3	96.6
Уурхайчин	83 025.9	72 914.1	87.8
Содон суварга	56 526.8	50 582.9	89.5

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2022 оны 1 дүгээр сарын 16

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах  
ТОГЛООМ 

Валютын ханш 



©2017


аппликейнаас

**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ аваарай**

**Data lab** | тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**

 [www.facebook.com/StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)

 [www.twitter.com/statistic\\_mn](http://www.twitter.com/statistic_mn)

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



[information@nso.mn](mailto:information@nso.mn)